

11/11/17

2017 оны 10 сар 20



А/448

Сургалтын хөтөлбөр батлах тухай

“Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай” хуулийн 8 дугаар зүйлийн 8.4, “Зэвсэгт хүчний тухай” хуулийн 6 дугаар зүйлийн 6.2.8, “Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай” хуулийн 270 дугаар зүйлийн 270.8 дахь заалтуудыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагад ажиллаж буй цэргийн жинхэнэ алба хаагаагүй цэргийн насны алба хаагчдад цэргийн бэлтгэл эзэмшүүлэх сургалтын хөтөлбөрийг хавсралтаар баталсугай.
2. Цэргийн бэлтгэл эзэмшүүлэх сургалтын хөтөлбөрийг 2017 оны 11 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн мөрдсүгэй.
3. Цэргийн бэлтгэл эзэмшүүлэх сургалтыг хөтөлбөрийн дагуу чанартай зохион байгуулахыг Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газарт хариуцуулсугай.

ДАРГА
ДЭСЛЭГЧ ГЕНЕРАЛ



Д.ДАВАА

ЗХЖШ-ын даргын 2017 оны 10 дугаар сарын 22-ны өдрийн 114 дугаар тушаалын хавсралт

ШҮҮХИЙН ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭХ БАЙГУУЛЛАГАД АЖИЛЛАЖ БУЙ ЦЭРГИЙН ЖИНХЭНЭ АЛБА ХААГААГҮЙ ЦЭРГИЙН НАСНЫ АЛБА ХААГЧДАД ЦЭРГИЙН БЭЛТГЭЛ ЭЗЭМШҮҮЛЭХ СУРГАЛТЫН ХӨТӨЛБӨР

Нэг. Үндэслэл

1.1. Хөтөлбөрийн зорилго

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагад ажиллаж буй алба хаагчдад цэргийн бэлтгэл эзэмшүүлэн албан үүрэгт нь сурган дадлагажуулах, тэдний бие бялдар, сэтгэл зүйн бэлтгэлийг нэмэгдүүлэхэд оршино.

1.2. Хөтөлбөрийн хариуцах эзэн, хамрах хүрээ

Цэргийн бэлтгэл эзэмшүүлэх сургалтыг Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын Сургалт арга зүй, олон нийттэй харилцах хэлтэс хариуцан зохион байгуулна.

Сургалтад Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагад ажиллаж буй цэргийн жинхэнэ алба хаагаагүй цэргийн насны алба хаагчид хамрагдана.

1.3. Сургалтын зохион байгуулалт, үргэлжлэх хугацаа

Цэргийн бэлтгэл эзэмшүүлэх сургалт нь 7 хоногийн хугацаатай, өдөрт 8 цагаар, нийт 56 цагийн сургалтаар зохион байгуулагдана. Хичээлийн нэг цагийн үргэлжлэх хугацаа 45 минут байна.

Цэргийн бэлтгэл эзэмшүүлэх сургалтад хамрагдсан алба хаагчдыг цаашид албаны сургалтаар "Харуул хамгаалалтын албаны ажилтан" бэлтгэх мэргэжлийн сургалтад хамруулна.


1.4. Удирдлага зохион байгуулалт

Цэргийн бэлтгэл эзэмшүүлэх сургалтыг Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын даргын тушаалын дагуу зохион байгуулна.

Сургалтыг газар зүйн байршил, цаг агаарын болон бусад хүчин зүйлээс шалтгаалан төвлөрүүлэн зохион байгуулах боломжгүй үед орон нутаг дахь хорих анги, шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар, хэлтэс зохион байгуулан явуулж болно.

Сургалтыг Зэвсэгт хүчний Жанжин штаб түүний харьяа анги, байгууллага болон Үндэсний батлан хамгаалахын их сургууль, Хууль сахиулахын их сургуультай хамтран явуулж болно.


Сургалтад хамрагдаж цэргийн бэлтгэл эзэмшсэн алба хаагчдыг Монгол Улсын Цэргийн тангараг өргүүлнэ.



Хоёр. Сургалтын хөтөлбөр

Хичээлийн нэр	Сэдэв	Хичээл	Сургалтын хэлбэр			
			Лекц	Семинар	Дадлага	Бүгд
1	2	3	4	5	6	7
2.1. Төрийн албаны бэлтгэл	Сэдэв-1 Монгол Улсын Батлан хамгаалахын багц хуулийн тухай	Хичээл-1 “Цэргийн албаны тухай” хуулийн бүтэц, агуулга.	2			2
		Хичээл-2 “Цэргийн алба хаагчийн эрх зүйн байдлын тухай” хуулийн ерөнхий ойлголт	2			2
	Сэдэв-2 Шүүхийн шийдвэр гүйцэтгэх үйл ажиллагаанд мөрдөгдөж буй хууль тогтоомжууд	Хичээл-1 Төрийн албаны тухай хуулийн бүтэц, агуулга	2	-	-	2
		Хичээл-2 Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн бүтэц, агуулга	4	-	-	4
		Хичээл-3 ШШГБ-ын шинэчлэн батлагдсан журмуудын талаар	2	-	-	2
	Хичээл-2 Хорих ангид ажиллах алба хаагчдын анхаарах зүйлс	1	-	-	1	
Бүгд			13	-	-	13
2.2. Цэргийн дүрмүүд	Сэдэв-1 Цэргийн дотоод албаны дүрэм	Хичээл-1 Цэргийн алба хаагчийн нийтлэг эрх, үүрэг, хүлээх хариуцлага, хоорондын харилцаа	3	-	-	3
		Хичээл-1 Нийтлэг үндэслэл, цэргийн алба хаагчид хүртээх сайшаал, шийтгэл түүнийг хэрэглэх журам	2	-	-	2
	Сэдэв-3 Цэргийн жагсаалын дүрэм	Хичээл-1 Нийтлэг үндэслэл, жагсаалын үндсэн тодорхойлолтууд	2	-	-	2
		Хичээл-2 Жагсаалд байгаа цэргийн алба хаагчийн үүрэг				
Сэдэв-4 Цэргийн хүрээний ба харуулын албаны дүрэм	Хичээл-1 Харуулын албыг зохион байгуулах нийтлэг үндэслэл	2	-	-	2	
Бүгд			9	-	-	9
Сэдэв-1 Зэвсэггүй жагсах үеийн жагсаалын ажиллагаа		Хичээл-1 Жагсаалыг үндсэн зогсолт, байран дээрх эргэлтүүд, байран дээрх ёсолж хүндэтгэх ажиллагаа			4	4
		Хичээл-2 Жагсаалын хөдөлгөөн, жагсаалын алхалт, явдал дундах эргэлт, хөдөлгөөн дунд ёсолж хүндлэх ажиллагаа			4	4

1	2	3	4	5	6	7
		Хичээл-3 Зэвсэгтэй жагсах үеийн ажиллагаа хөдөлгөөн	-	-	4	3
		Хичээл-4 Жагсаалаас гарах, даргад очих, даргаас буцах	-	-	4	3
Бүгд			-	-	16	16
Зэвсэг техникийн бэлтгэл						
2.4. Галын бэлтгэл	Сэдэв-1 Автоматын үүрэг зориулалт, бүтэц, зохион байгуулалт, ажиллагаа	Хичээл-1 Алба хаагч нэг бүрийн буудлагын зэвсэглэл /АК, АКМ, АКМС/-ийн үүрэг зориулалт, бүтэц зохион байгуулалт, ажиллах зарчим сумны үүрэг зориулалт, төрөл, ангилал	1	2		3
		Хичээл-2 Автоматыг задлаж, угсрах, эд анги механизмудын үүрэг зориулалт ажиллагаа	1	2		3
		Хичээл-3 Шагайврын дадлага	-	2	1	3
	Сэдэв-2 Автоматын анхны дасгал	Хичээл-1 Автоматын анхны дасгал боловсруулах	-	-	1	1
Бүгд			2	6	2	10
2.5. Биеийн тамирын бэлтгэл	Сэдэв-1 Биеийн ерөнхий хөгжлийн дасгал, гимнастикийн дасгал, хөдөлгөөн, ойрын болон дундын зайн гүйлт	Хичээл-1 Бие халаалт, биеийн ерөнхий хөгжлийн дасгалууд	-	-	1	1
		Хичээл-2 Бие халаалт, биеийн ерөнхий хөгжлийн дасгалууд, дүүжин суниах, түүний хөндлөвчинд биеэ савахгүйгээр хөлөө хүргэх мөн татаж давах дасгал	-	-	1	1
		Хичээл-3 Бие халаалт, биеийн ерөнхий хөгжлийн дасгалууд, модон морин дээгүүр харайх	-	-	1	1
		Хичээл-4 Бие халаалт, биеийн ерөнхий хөгжлийн дасгалууд, савлуурт суниах модон моринд чөлөөт харайлт, хөлийн булчингийн дасгал	-	-	1	1
		Хичээл-5 Бие халаалт, биеийн ерөнхий хөгжлийн дасгалууд ойрын зайн гүйлт /60, 100, 200м/, хэвтээ, суугаа, босоо гараанаас хурд авах дасгал	-	-	2	2
		Хичээл-6 Бие халаалт, биеийн ерөнхий хөгжлийн дасгалууд, буухиа гүйлтүүд /4x60, 4x100, 4x200м/	-	-	2	2
Бүгд			-	-	8	6
Нийт – 56 цаг			24	6	26	56



Гурав. Хүрэх үр дүн

Сургалтад хамрагдсан алба хаагч нь цэргийн хэргийн мэдлэг эзэмшиж, жагсаалын ажиллагаа хөдөлгөөнийг гүйцэтгэх дадалд суралцан, албанд ашиглагдаж буй зэвсэг, тусгай хэрэгсэлтэй ажиллах чадвар эзэмшинэ.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх, албан үүрэг гүйцэтгэхтэй холбогдолтой хууль эрх зүйн мэдлэг эзэмшинэ.

ЗЭВСЭГТ ХҮЧНИЙ ЖАНЖИН ШТАБ

